



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 296

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам” ып 6.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар тогтоолд заасан, 166,138,000.00 /нэг зуун жаран зургаан сая нэг зуун гучин найман мянган/ төгрөгийн балансын үнэ, 94,606,361.02 /ерэн дөрвөн сая зургаан зуун зургаан мянга турван зуун жаран нэгэн төгрөг хоёр мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээд /Орон нутгийн өмчийн алба/-д эзэмшигчилэх, ашиглаулах, данс бүртгэлд тусгах, ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Эрчим хүчний яамны нэр дээр гэрчилгээтэй автомашины эзэмшигчийг шилжүүлсэн тодорхойлолтыг арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


3. МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭГТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000392

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн
296.. дугаар тогтоолын хавсралт



Эрчим хүчний яамны нэр дээр бүртгэлтэй төрийн өмчийн
данс бүртгэлээс хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Ландкрайзер-200, 75-53 УНД арал № JTMHU09JX04081777	2013/ 2013	166,138,000.00	94,606,361.02
	Нийт дүн		166,138,000.00 /нэг зуун жаран зургаан сая нэг зуун гучин найман мянган/	94,606,361.02 /өрөн дөрвөн сая зургаан зуун зургаан мянга гурван зуун жаран нэгэн төгрөг хоёр мөнгө/